

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Хөнхөрийн Мооно	Дугаар	L141
Оршин суугаа аймаг	Сүхбаатар	Оршин суугаа сум	Дарьганга
Төрсөн газар	Дарьганга	Төрсөн он	1948
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Овоон сүм	Сүм хийдийн дугаар	СБДГ 005
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 25	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Овоон сүм

-Танай нутагт ямар ямар сүм хийд байв?

Дарьгангад Овоон сүм, Рашаантын хийд, Бадрахын сүм / Бадрахын баруун талд/, Их бургасны сүм / Бургасан дуган/ гэсэн сүм хийдүүд байсан.

Лхаамаа гуай Бадрахын сүм нурсан үед нэг Дарь-Эх бурхан авах гээд нүднээс нь айгаад авч чадаагүй гэж ярьдаг. Дарьганга хошуунд: Дарьганга, Наран, Онгон, Халзан, Асгат, Түвшин ширээ, Баяндэлгэр зэрэг сүм орно.

Их бургасны худгаас баруун тийш хоолойд Их бургасны сүмийн туурь байгаа. Овоон сүм 1000 ламтай гэж ярьдаг боловч би 100 байсан болов уу гэж боддог. Жамбадаржаалин хийд нэртэй байсан. Хамгийн сүүлийн дуганд нь сүүлд эмнэлэг орсон. Энэ хийдийн том хонх хаа нэг газар булаастай байгаа гэж дуулсан. Рашаантын хийд бол том хийд байсан бололтой. Харин Их бургасны сүм жижиг байсан. Овоон сүмийн хамба Жамбаа гэдэг хүн байсан. Манай нутгийн Улаанбаатар хотод амьдардаг Лувсанноров гэдэг хүн Овоон сүмийн талаар материал их цуглуулсан бас судалдаг хүн байгаа.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

1999 онд хэвлэгдсэн газар шороо хэмээх нэртэй сонины тусгай дугаарт С.Лувсанноровын бичсэн “Хэлмэгдэгсэддээ зул өргөө” хэмээх материалд Дарьгангын 6 сумаас 1938-1939 лам, хар нийлээд 366 хүн үлс төрийн хилс хэрэгт хэлмэгдэн цагаатгагдаж гарч байна. Тэдний 284 нь цаазлагдаж , 72 нь 7-10 жилийн хорих ялаар шийтгүүлсэн байна. Дарьганга сумын Овоот, Рашаант, одоогийн Наран сумын нутаг малчид, Гүн худаг, Сайн худаг зэрэг сүм хийдийн 143, Асгат сумын Бөөрийн хийдийн 42, Онгоны цагаан худаг, Дэрсэн худаг, Их булагийн хийдийн 67, Баяндэлгэр, Хонгор, Халзан сумдын Ширээт, Өгөөмөр, Ламт, Бударгана, Хатавчийн сүм хийдэд сууж байсан 114 лам хуврагийг хэлмэгдүүлжээ. Тэдний олонх нь буюу 219 нь 40-59 настай, бурханы номын ухаанд гүнзгийрсэн, шашны ёс жаягаа дээдэлсэн, лам, гэлэн, гэвш, зурхай зэрэг ажил мэргэжлээрээ төрөлжсөн эрх мэдэлтэнгүүд байсны дээр 60-84 настай, 90 шахуу тооны хамба, гавж, аграмба, аранжамба, лхаарамба, маарамба цол хэргэмтэй томхон эрдэмтэн лам нар байжээ. Овоон хийдийн лам Гонгорын Жамба 19 настайдаа Өлзийбаярын Сэдэд, Мэнжээгийн Дамдинжав, Хонгор сумын Галсанжамцын Ядамсүрэн, Доржийн Лувсантавхай нар дөнгөж 20 настайдаа хэлмэгдсэний дээр 80 настай Жанцын Жамъян /Дарьганга/, 84 настай Хутагийн Лувсаншарав /Онгон/ нарын настан буурлууд өчиггүй хороогджээ. “Газар шороо” сонины 2005 оны 07 дугаар сарын дугаар нь Дарьгангын 80 жилийн ойд зориулсан тусгай дугаар бөгөөд энэ сонинд “Өрлөг түүхийг сөхвөл” хэмээх хэсэгт сүрэг байгуулагдсаны дараа нутгийн зөн олон тахилгат овоог бий болгох асуудлаар зарга үүсгэж, Манжийн хааны зарлигаар Захын хар өндөр буюу Дарь овоог жил бүрийн хавар, намрын эхэн сард жилд 2 удаа тахих болсон бөгөөд алтанганжирийг Батцагааны оройд байрлуулсанаас үүдэн Алтан овоо хэмээн алдаршиж өөрийн тахилгын ном, тарни, магтаалтай болсон байна. Дарьгангад бүгд 18 сүм хийд байсан дотроос гол сүм нь Овоон сүм байлаа. Дарьганга хошуунд Халзан, Дарьганга, Асгат, Онгон сум Баяндэлгэр , Түвшинширээ , Наран сумдууд ордог байсан байна. Түүхийн ухааны доктор Хэрэйд Жамсрангийн бичсэн “Дуунд мөнхөрч, сэтгэлд шингэсэн домогт Тоорой Банди” хэмээх нийтлэлд Тоорой Бандийн намтарыг ингэж өгүүлжээ. Эх нь хүүгээ хуврага болгох санаатай тул нутгийнхаа Бургасан дуган гэдэг хуралд суулгасан боловч Нанзад хүү шашны номлолд лам багшийн хатуу дарангуйлалд дургүйцаж, дуганаа орхиж гэртээ буцаж ирээд эхтэйгээ хамт амьдрах болжээ. Бас хааны зарлигаар Орлой мэргэн хутагтыг Дарьгангачуудын шүтээн лам болгосон байна. Дарьгангын Алтан овооны судар төвд хэлээр зохиогдсон нь өдгөө уламжлагдан иржээ. Тэдгээрээс нийтэд алдаршсан нь Эрдэнэ мэргэн хутагтын хувилгаан Лувсанжигмэддорж, Равжинлуvsанбалжир хоёрын захиалгаар төвдийн Банчэн лам Лувсанбалданчоглоонамжилын төвд хэлээр найруулан зохиосон “Газар баригч Дарьганга орны эзэн буяны сад ан нөхөр сэлтийн илт онол заллага хангал тахилга” хэмээх судар болно. Дарь уулын чанх орой дээр Алтан ганжирт Батцагаан овоо байжээ. 1927 онд Оросын эрдэмтэн Казакевич “Дарьгангаар аялсан нь” гэдэг номоо 1930 онд Ленинграддад хэвлүүлсэн бөгөөд түүндээ “Батцагаан шиг нэн ховор дурсгалыг хаана ч олж үзээгүй” гэж гайхан бичсэн байжээ.